

## ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ БАГУУД



*Багийн дарга нар Б.Довуучий, Г.Сосорбурам, Б.Баатарсүрэн*

### **БАЯНБУЛАГ БАГ**

Бага газрын чулуунаас үүдэлтэй Баянбулаг баг нь 1992 онд үүсэн байгуулагдсан. Тус багт орших байгалийн үзэсгэлэнт газар болох Бага газрын чулуун 2011 онд Улсын Их хурлын тогтоолоор Улсын тусгай хамгаалалттай бүс нутаг болсон. Бага газрын чулууны уул нь 86.3 мянган га газар нутаг эзлэн оршдог. 2009 онд тус уулыг сумын Тахилгатай уул болгосон. Багийн нутагт түүх соёлын дурсгалт газар, булш, бунхан хадны сүг зургууд их бий. Ан амьтан ихээр амьдардаг жишээлбэл аргал, янгир, цагаан зээр, үнэг, чоно, хярс, могой, дорго, тас, бүргэд, шонхор зэрэг ан амьтантайгаас гадна, сүм, агуй, сүв, хоолой, олон төрлийн эмийн ургамал, рашаан зэрэг байгалийн тогтоц ихтэй нутаг. 1992 шинэ засаг захиргааны өөрчлөлтөөр анхны багийн Засаг даргыг томилсон нь Б.Баатарсүрэн байсан. Түүний дараачаар 1996 онд Н.Эрдэнэ-Очир 4 жил, Ю.Бавуудорж 12 жил, П.Амгаланбаатар 4 жил, П.Мөнхзориг 6 жил, 2022 оноос Б.Довуучий ажиллаж байна. Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Засгийн газар, Сумын Засаг

дарга, багийн засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багийн хамт олны идэвхийг өрнүүлэн иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх, хуулийг суртчилан таниулах, төрөл бүрийн судалгаа хийх, тооцоо тайлан гаргах ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна.

Тус баг нь 2022 оны жилийн эцсийн хүн ам, малын тооллогоор 202 өрхийн 587 суурин хүн амтай. Малчин өрх 154 өрхийн нийт 68487 толгой мал тоолуулснаас тэмээ 158, адуу 2269, Үхэр-1636, хонь-31099, ямаа-32410 толгой мал тоолуулсан.

Улсын аварга малчид:

Улсын хошой аварга тууравч Д.Орго, Улсын аварга малчин Гэндэнгийн Лхагва, улсын аварга малчин Ц.Болоож, улсын аварга малчин Г.Батбазар, улсын аварга малчин Б.Тагарваа нар байна.

### **ЦАХИУРТ БАГ**

Монгол улсын шинэ үндсэн хуулийн дагуу засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьлалтын дагуу “**цахиурт**” баг 1992 онд үүссэн байгуулагдаж анхны багийн засаг даргаар Лхагвын Ням-очир / 1992-1997 /, Нямын Загдхорол / 1997-2006/ , Гүнсэнмоломын Сосорбурам 2006 оноос одоог хүртэл ажиллаж байна.

Нутаг дэвсгэрийн хил заагаар зүүн талаараа өөрийн аймгийн дэрэн сум, урд талаараа Дэлгэр-эмт баг, баруун талаараа Баянбулаг баг болон хойд талаараа төв аймгийн баяннөжүүл сумтай хиллэдэг.

сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 2018 онд “Цахир” –ын уулыг сумын тахилгат уул болгосон ба “Номт” хайрханыг олон жил бригадын дарга, тоо бүртгэгчээр ажилласан Ядамжав агсаны үр хүүхэд, ач зээ тайн уул овоогоо баясгаж уламжлал болгоод байгаа билээ.

Уул толгод, тал хээрийн бүс нутаг дэвсгэрт Цахирын уул, Халтарын уул, Баянгийн булаг, Адгийн булаг, Замын төгрөг, Баянхошуу зэрэг олон мянган малыг ундаалж байдаг худаг ус арвинтай өгөөжөө өгсөн нутаг билээ.

Тус баг нь 2022 оны жилийн эцсийн хүн ам, малын тооллогоор 189 өрхийн 515 хүн амтай. Малчин өрх 116, мал бүхий 19 өрхийн нийт 63159 толгой мал тоолуулснаас тэмээ 422, адуу 3570, үхэр 1705, хонь 29892, ямаа 27570 толгой мал

тоолуулсан байна. Цахиурт баг нь Цагаан дэл, Алтанзагас лагерийн өрх, хүн ам харъяалагдаж төв хөдөөгийн холимог баг юм.

Тус багаас монгол улсын манлай уяач Ц.Цэрэнбал, монгол улсын алдарт уяач Б.Цэрэндагва, Ц.Хүүхэнбаатар,

Аймгийн алдарт уяач Л.Цагаан, О.Гангар, Л.Эрдэнэбаяр, Д.Нямсүрэн, Да.Гантөмөр, Г.Гансүх, Д.Нэргүй,

Сумын алдарт уяач Ц.Сэнгэдагва, Г.Сосорбурам, Г.Сүхболд, Ш.Цэгмэд, О.Отгонбат

Монгол улсын аварга малчин Д.Нямсүрэн, Ду.Гантөмөр, Л.Эрдэнэбаяр, Б.Балдорж, Г.Гансүх.

Аймгийн аварга малчин тууварчин Л.Пүрэв, П.Дашцэрэн, Б.Дашдаваа, Ц.Дашдорж, А.Эрдэнэбат, О.Батсайхан, Б.Туваан, Б.Ганболд, Б.Доржсүрэн, А.Эрдэнэтөгс.

Сумын мянгат малчин Ц.Цэрэнлхам, Х.Цоодол, Х.Отгонбаяр, Ц.Баясаа, Б.Балдорж, Д.Нямсүрэн, Г.Гансүх, Да.Гантөмөр, С.Жаргалсайхан, А.Эрдэнэбат, Б.Жамбал, Ю.Бямба, О.Баярдорж, Ц.Отгонжав, Ц.Цэсэм, Ду.Гантөмөр, Л.Эрдэнэбаяр, О.Батсайхан, Д.Мөнхбаатар, Ц.Баянмөнх, А.Эрдэнэтөгс, Б.Туваан, Б.Бадамсамба, Б.Бадамхүү, Э.Намжилдорж, Б.Доржсүрэн, Б.Ганболд, О.Отгонбат, Н.Баттулга, Ц.Идэр, Г.Сүхтөмөр, Д.Батжаргал, Ю.Цолмонбаатар нарын алдартнууд төрөн гарсан өлгий нутаг билээ.

## **ДЭЛГЭР-ЭМТ БАГ**

Монгол Улсын Шинэ үнсэн хуулийн дагуу Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарилалтын дагуу “ДЭЛГЭР-ЭМТ” баг 1992 онд үүсэн байгуулагдаж Анхны багийн паргаар Пүрэвийн Амгаланбаатар ажиллаж байсан түүхтэй.

1996 оноос ойш орон нутгийн сонгуулийн өөрчлөлтөөр Багийн засаг даргаар Б.Баатарсүрэн 8 жил, П.Түвшинсайхан 16 жил ажиллаж, Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн биелэлтийг хангах Монгол улсын Засгийн газрын

бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэд олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна.

Нутаг дэвсгэрийн хил зааг нь зүүн талаараа өөрийн аймгийн Дэрэн сум, урд талаараа Сайнцагаан сум, баруун хойд талаараа Адаацаг сумтай хиллэдэг.

Дэлгэр-Эмт багийн байгалийн үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газар Дэлгэрийн Чойрын хийдийг Хамба лам И.Гэмпил, Т.Мятав, Н.Чой нарын олон лам нар сэргээн засварлаж анхны майдарын үйл ажиллагааг нутгийн ард иргэд, сүсэгтэн олонтой хамтран 1990 онд зохион байгуулж байсан түүхтэй.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 2018 онд “ЭМТИЙН ШИРЭЭ” уулыг сумын тахилгат уул болгон жил бүр тахьдаг уламжлалтай болсон.

Нутгийн уугуул иргэдийн санаачилгаар “АРВАН ГУРАВТ” уулыг Улаанбаатар нутгийн зөвлөлийн тэргүүлэгч, Чоён Од Салин хийдийн лам нар, нутгийн зон олон тахих ёслолыг гүйцэтгэдэг сайхан уламжлалтай болжээ.

Уул толгод, тал хээрийн бүс нутаг дэвсгэрт Их дэлгэрийн уул, Халтарын уул, Эмтийн ширээ, Суваргын булаг, Ар булаг, Хар чулуутын булаг, Хөвийн булаг, Шаргалын булаг зэрэг байсан ба одоо Эмтийн ус олон түмний олон мянган малыг ундаалж байдаг элбэг устай Эмтийн усаар алдартай билээ.

Дэлгэр-эмт баг 173 өрхийн 488 хүн амтай, 44640 толгой малтай. Манай багийн ажилсаг хөдөлмөрч хамт олны дундаас ажил хөдөлмөрийн амжилтаар аймгийн хошой аварга малчин 1, аймгийн аварга малчин 9, аймгийн аварга саальчин 2, аймгийн алдарт уяач 5 мянгат малчин 13 төрөн гарчээ.

Одоо Б.Баатарсүрэн баг хамт олныг удирдан чиглүүлж Багийн Засаг даргаар ажиллаж байна.

## ДЭЛГЭР-ЭМТ БАГИЙН АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН БАЙСАН

1. Гончиг Цэвээнбалжир “аймгийн хошой аварга”
2. Түмэн Дашжамц
3. Сугир Лувсан-Иш
4. Баяр Ниндсүрэн

### 1990 ОНООС ХОЙШИХ АЙМГИЙН АВАРГА МАЛЧИД

- |                           |      |
|---------------------------|------|
| 5. Бавуудорж Батсайхан    | 856  |
| 6. Гончигдавга Батчулуун  | 1063 |
| 7. Гомбосүрэн Цогтбаатар  | 1058 |
| 8. Доржпүрэв Мөнх-Эрдэнэ  | 1176 |
| 9. Пүрэв Доржсүрэн        | 1950 |
| 10. Сэнгэдаа Жаргалсайхан | 1019 |

### АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧИД

1. Доржпалам Дашням 1978 он
  2. Даарийн Мөнхжаргал 2023 он
- ### АЙМГИЙН АЛДАРТ УЯАЧИД

1. Сугирын Лувсан-Иш
2. Зандарын Цэдэвсүрэн
3. Зундуйн Содномпэл
4. Лувсангийн Төрмандах
5. Гончигдагва Бөхчулуун

### БАГИЙН МЯНГАТ МАЛЧИН БОЛСОН ӨРХҮҮД

1. Сэнгээ Эрдэнэбат
2. Дашдаваа Түвшинбаатар
3. Доржпүрэв Эрдэнэчулуун
4. Сувдаа Мөнх-эрдэнэ
5. Пүрэвсүрэн Мөнхдалай
6. Эрдэнэчулуун Чинзориг
7. Дулмаа Цолмон
8. Сугирдорж Ганболд 1003
9. Гончигдавга Улаанхүү 1023
10. Цэрэндогоо Нямцэрэн 1024
11. Алтангэрэл Батболд 1088
12. Сүрэнхор Дондов 1114
13. Лувсан-Иш Гарам 1825